213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	714,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>521,451,200.00</b>	<b>517,671,316.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>-</b>	<b>-</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>521,451,200.00</b>	<b>517,671,316.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	521,451,200.00	517,671,316.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23.00</b>	<b>22.00</b>
620001	Удирдах ажилтан	7.00	7.00

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
620004	Гэрээт ажилтан		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23.00</b>	<b>22.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15.00	15.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШҮ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШҮ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	2.00
650010	Гэрээт ажилтан	5.00	5.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,984,044.00</b>	<b>4,387,415.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,984,044.00</b>	<b>4,387,415.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	10,984,044.00	4,387,415.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	716,000.00
210101	Үндсэн цалин		
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		716,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,860,000.00	1,491,415.00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун	1,530,000.00	1,481,415.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00	10,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	330,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		330,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	160,000.00	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	160,000.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,964,044.00	1,850,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,964,044.00	1,850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	10,984,044.00	4,387,415.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,984,044.00	4,387,415.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,530,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,454,044.00	4,387,415.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Засаг даргын тамгын газрын тайлант оны зорилгыг “Төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүртээмжтэй болгоно” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- ” Төрөөс иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүрээнд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх”

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд ямар нэгэн хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 11 сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.9 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	537	252.90	
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	21,967.00	22,340.40	-373.40
Үндсэн хөрөнгө	1,172,403.20	1,190,245.10	-17,841.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,194,907.20</b>	<b>1,212,838.40</b>	-17,931.20
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,194,907.20	1,212,838.40	-17,931.20

<b><u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u></b>	<b>1,194,907.20</b>	<b>1,212,838.40</b>	<b>-17,931.20</b>
-----------------------------------------------------	---------------------	---------------------	-------------------

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Засаг даргын тамгын газар нь оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 3.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үндсэн санхүүжилтийн дүнгээс 3.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дүнгээс мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

Оны эхэнд байсан ХХОАТ-ын 0.5 сая төгрөгийн авлагаас тайлант онд 0.3 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Төсвийн хөрөнгөөр 82.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 10.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 42.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 22.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна. Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 17.8 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 95.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна. Холбогдох байгууллагын шийдвэрээр 19.9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг шилжүүлж, 48.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөд 78.2 сая төгрөгийн элэгдэл байгуулж, шилжүүлсэн буюу акталсан үндсэн хөрөнгийн 68.3 сая төгрөгийн элэгдлийг бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 17.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 617.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 617.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 95.6 сая төгрөгөөр бууруулан, 521.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 599.8 сая сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 521.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 517.7 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*  
*/мянган төгрөгөөр/*

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагааны орлого	426,962.60	425,496.50	1,466.10	99.66
80102	Туслах үйл ажиллагааны зардал	73,699.60	73,139.70	559.90	99.24
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	714.00	714.00	-	100.00
80701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	20,075.00	18,321.10	1,753.90	91.26
	<b>Дүн</b>	<b>521,451.20</b>	<b>517,671.30</b>	3,779.90	99.28

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 1.5 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны хөтөлбөрөөс 0.6 сая төгрөгийг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрөөс 1.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 4.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, урамшуулалд 0.7 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 1.5 сая төгрөгийг, хоол хүнсний зардалд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулж, бараа үйлчилгээний бусад зардалд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 36.0 сая төгрөгийн бараа материал, 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/14 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 487.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 613.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.2 сая төгрөг болж байна.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Сумд 1 орлогч дарга ажилласан. Тээврийн хэрэгслийг сум дотор ашиглаагүй, аймагт болон хөдөө ажиллахад ашигласан байна. Төсвийн хөрөнгөөр 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53.2 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 97.7 хувьтай байна. Төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой 948.0 мянган төгрөгийн 18 шийдвэрийг хугацаа хоцроож оруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53.2 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй зөрчилд зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудсанд төсөв, мөнгө, хөрөнгө зарцуулсантай холбоотой гарсан 12 тушаал шийдвэрийг байршуулаагүй байсан зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж цахим хуудсанд нөхөн байршуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100%
Нийт дүн	1	0	1	0	100%

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,299.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 14,299.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрээс 3779.9 мянган төгрөгийн төвлөрүүлсэн орлогыг цэвэрлээгүй тайлагнасныг залруулав.
- Санхүүгийн үр дүнгийн орлогын тайлангийн орлого талын хөрөнгийн санхүүжилт хэсэгт үнэ төлбөргүй хүлээн авсан 10,520.0 мянган төгрөгийн бараа материалын орлогыг оруулж тайлагнасныг үнэ төлбөргүй авсан бараа материалын орлого хэсэгт оруулж залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 169,418.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 169,418.3 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

Аудитаар 169,418.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

#### 1.1.Илрүүлэлт:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн бүгд 59,820.7 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 14.4.1, 14.4.5, 14.4.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг хэрэгжүүлээгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 1.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн зардлыг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

## **2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### 2.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 8107.1 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон, ажилтнуудын цалинг шинэчилж тогтоогоогүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

#### 2.1. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу ажилтнуудын цалинг он эхэнд шинэчлэн тогтоох, эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 2.2 Илрүүлэлт:

1.Аймгийн ИТХ-ын 2023 оны 3 дугаар сарын 23-ын өдрийн 156 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийн бүртгэлээс 48,342.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан боловч устгалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-д " худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", 31.3.3-т "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 8 дугаар зүйлийн 8.3-т "8.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана" гэснийг зөрчсөн байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Тайлант онд акталж, данснаас хассан 48,342.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу устгах.

## **3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### 3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53.2 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 97.7 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4 дэх хэсгийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

### 3.2. Өгсөн зөвлөмж:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53.2 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн байршуулан мэдээлж, зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	2	14299.9	0	0	2	14299.9	2	14299.9				
Дүн	2	14299.9	0	0	2	14299.9	2	14299.9				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын байгууллагад

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

									албан шаардлага		шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн	3	116270.6					3	116270.6				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>116270.6</b>					<b>3</b>	<b>116270.6</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудсан мэдээлээгүй орхигдуулсан	1	53147.7						1	53147.7
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>53147.7</b>						<b>1</b>	<b>53147.7</b>